



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 360

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 3, 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 196,773,098.00 (нэг зуун ерэн зургаан сая долоон зуун далан гурван мянга ерэн найман) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 7 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганболд, тус яамны харьяа байгууллагуудын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримт, автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтын хамт 2020 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны... дугаар сарын... ны өдрийн
360 дугаар тогтоолын хавсралт

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ХАРЬАА БАЙГУУЛЛАГУУДЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН
ХУДАЛДАГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Сэргээн босголтын зардал /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1.Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа						
1	УАЗ-220692033, 3190 АРХ, суудлын, арал 374100D0422345	2013/2013	161505	25,500,000.00	0	1,000,000.00
	Дүн	-		25,500,000.00		1,000,000.00
2.Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа						
2	УАЗ-220692033 4475 БӨТ, суудлын, арал 374100D04211391	2013/2014	80822	25,500,000.00	0	1,000,000.00
	Дүн			25,500,000.00		1,000,000.00
3.Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргаа						
3	УАЗ 31512, 7802 ДОО, суудлын, 80505738	2008/2008	250000	14,000,000.00	0	800,000.00
	Дүн			14,000,000.00		800,000.00
4.Хөх сэрхийн нурууны улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа						
4	УАЗ-3151229, 9165 БӨА, суудлын, арал 80512188	2008/2008	27884	14,476,690.00	0	800,000.00
	Дүн			14,476,690.00		800,000.00

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Сэргээн босголтын зардал /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
5.Орхон Чулуут голын сав газрын захиргаа						
5	Тоёота Ландкрузейр-100 7516 ОРХ,суудлын, арал JTECJ09J005508375	2002/2017	337157	43,413,000.00	0	1,500,000.00
	Дүн			43,413,000.00		1,500,000.00
6. Хөгнө-Тарни байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа						
6	Уаз-31512 52-72 УБТ, суудлын арал 80510020	2008/2008	214500	14,000,000.00	0	800,000.00
	Дүн			14,000,000.00		800,000.00
7.Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа						
7	Ланд крузейр-105, суудлын 76-37 УНИ, арал JTECJ09J905512618	2007/2015	187524	59,883,408.00	0	10,000,000.00
	Дүн			59,883,408.00		10,000,000.00
	НИЙТ ДҮН	-		196,773,098.00		15,900,000.00
				(нэг зуун ерэн зургаан сая долоон зуун далан гурван мянга ерэн найм)		(арван таван сая есөн зуун мянга)